

“ЦЭРЭГ, (ЦЭРГИЙН)” ГЭХ ҮГИЙГ АНГЛИ ХЭЛЭЭР ОРЧУУЛАХ БОЛОМЖУУД

(монгол-англи хэлний зарим жишээн дээр)

Р.Онон⁴²

Товч утга: Орчуулгын дүйцэлийн онол ёсоор бол тухайн гадаад үгний утгыг яв цав буулгана гэдэг харьцангуй ойлголт юм гэж үздэг. Монгол хэлэнд ганцхан утга бүхий цэрэг (цэргийн) гэсэн үгэнд англи хэлний гурваас доошгүй үгний (troops, soldier, military) аль нэгийг сонгон оноон орчуулах шаардлага тулгардаг нь бэрхиээл учруулдаг. Энэ хүндрэлийг хэрхэн гэтлэн давах боломжийн талаар зохиогч өөрийн саналаа дэвшүүлжээ.

Түлхүүр үг: цэрэг (цэргийн), явцуу хүрээний нэр томьёо, орчуулга, ойролцоо утгатай үг, дүйцэл

Монгол хэлэнд цэрэг хэмээх ганц нэгэн утга агуулсан мэт үг нь англи хэлнээ түүнээс олон буюу цөөн хэдэн янзын өөр өөр үгээр буулган орчуулдаг, тэр нь тухайн гадаад хэлэндээ явцуу хүрээний мэргэжлийн цэргийн албан хэл, нэр томьёо талаасаа тогтож хэвшсэн байх нь элбэг учир үүнийг зөв буулгаж орчуулан ойлгосноор оюутан, мэргэжлийн бус хүмүүс буруу зөрүү ойлгон орчуулахаас урьдчилан сэргийлэх үүднээс энэхүү сэдвийг хөндөхийг зорилоо.

Орчуулгын онолын үүднээс аливаа нэгэн дүйцэх орчуулга гэдэг нь “Translation adequacy is achieved by three types of regular correlations:...2) analogs, or variable, contextual correspondence, when the target language possesses several words to express the same meaning of the source language word: soldier – солдат, рядовой, военнотружашчий, военный.”⁴³ Энэхүү жишээнд цэрэг хэмээх үгийн гол утга санаа нь тухайлбал, англи хэлнээс орос хэл уруу тухайн хам сэдэв, ойролцоо утга мэтээс хамаараад ийм олон янзын ижил үгээр оноон хөрвүүлж болох хэдий ч хамгийн чухал нь үндсэн утгаа алдалгүй хадгалж чадсанаар орчуулгын дүйцэл ямар нэгэн хэмжээгээр хангагдсан гэж үзэх бүрэн үндэстэй ажээ.

Цэрэг гэсэн үгийн гарлыг “зэрэг” гэсэн үгний утгаас гаралтай гэх ам дамжин тайлбарлах явдал бий. Харин нэрт эрдэмтэн, академич Д. Төмөртоогоо үзэхдээ үгийн гарал талаасаа цэрэг гэдэг нь “...байлдагч...Монгол, түрэг хэлний дундын үг.”⁴⁴ ажээ. Цэрэг хүн гэж хэн бэ, ямар алба ажил хашдаг тухай монгол хэлний цахим их тайлбар

⁴² УБХИС-ийн ГХСТ-ийн англи хэлний багш

⁴³ Zoya Proshina “Theory of Translation” (English and Russian), Vladivostok., Far Eastern University Press., 2008

⁴⁴ Д.Төмөртоогоо “Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь” УБ.,2018 он, 20-р талд

тольд “1. Улсын зэвсэгт хүчинд байлдагчийн үүрэг хүлээсэн хүн: **цэрэг болох** (цэрэгт татагдаж байлдагч болох), 2. Цэргийн цолтой бүх хүмүүс.”⁴⁵ гэж тун тодорхой тайлбарлажээ.

Тэгвэл БХИС-н харьяа Батлан Хамгаалахын Эрдэм Шинжилгээний Хүрээлэнгээс эрхлэн гаргасан “Цэргийн нэр томъёоны тайлбар толь”-д (2014) *Цэрэг* гэдэг нь “...ерөнхий утгаар: 1) цэргийн цолтой бүх хүмүүс, ахмад дайчид (хуучин цэрэг)-ын ай нэр. 2) Зэвсэгт хүчний бүтэц дэх ай цэрэг, төрөл, тусгай мэргэжлийн цэрэг. Тухайлбал, хуурай замын цэрэг, гэнгисийн цэрэг, агаарын цэрэг, инженерийн цэрэг, химийн цэрэг г.м; 3) явцуу (нарийн тодорхой) утгаараа олонх улс орны цэргийн байгууллагад хугацаат болон гэрээт цэргийн албан хаагчид.”⁴⁶ гэж тайлбарлажээ. Энэхүү тайлбар бол мэргэжлийн хүмүүсийн хамгийн оновчтой, тухайн үгийн олон ойролцоо утгыг үнэн зөв гаргасан гэж үзэж болно. Учир нь англи хэлэнд тухайн *цэрэг* гэсэн үгээ хөрвүүлэхийн урьд энэ олон ойролцоо утгын учир холбогдлыг ойлгох анхны хэрэгцээ ингэснээр цаад хэлэндээ ч тэр өөрийн хэл уруу ч мөн адил оновчтой зөв үгийг олж сонгон авах, утгыг яв цав буулгах суурь боломж бололцоо бүрдэх учиртай юм.

Англи хэлний *soldier* буюу *цэрэг* гэх үгийн уг гарал, утга, агуулга монгол хэлнийхээс бүрмөсөн зөрдөг. *Soldier* нь үгийн уг гарвалаараа англи хэлний цахим тольд тодорхойлсноор “Middle English: from Old French soldier, from soulede ‘(soldier's) pay’, from Latin solidus (see solidus). The verb dates from the early 17th century.”⁴⁷ хэмээжээ. Үүнээс үзвэл, энэ үгийн үндсэн утга “төлбөр; хөлс мөнгө; шан харамж” гэдгээс үүссэн байна. Цаад нарийн утга нь яг үнэндээ “хөлс, мөнгөний ажил эрхлэгч нэгэн” гэсэн санааг илэрхийлнэ. Түүхээс авч үзэхэд тухайн цагт, дундад зууны Европт ивд олон тооны хан, ханлиг, ван тус тусдаа бие даасан байдалтай аж төрөн суудаг, тархай бутархай, өөрөөр хэлбэл, нэгэн улс үндэстэн гэсэн ойлголт хараахан төлөвшин бий болж амжаагүй байсан гэдэг. Иймээс өөр өөрсдийн хөлсний багахан цэргийн хүчээр сахин хамгаалан тус тусын цайзанд бэхжин хоргодон суудаг байсан тухай түүхэн ном зохиолд өгүүлжээ.⁴⁸

Бас нэг өөр жишээ татахад, миний ажил олгогч байгууллага болох ҮБХИС (Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль) нь угтаа дээхэн цагт ерөөсөө Цэргийн Сургууль бөгөөд энэхүү түүхэн нэрээ 10 гаруйхан жилийн өмнө, саяхан хүртэл хадгалж байв. “...Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль нь:

1921-1923 онд Ардын цэргийн даргын сургууль

1923-1932 онд Бүх цэргийн ерөнхий сургууль

1932-1966 онд Цэргийн ерөнхий сургууль

1966-1991 онд Цэргийн ерөнхий болон Нэгдсэн дээд сургууль

⁴⁵ <https://mongoltoli.mn/dictionary/detail/126359>

⁴⁶ “Цэргийн нэр томъёоны тайлбар толь” УБ., 2014, 365-р талд

⁴⁷ www.webster.com

⁴⁸ Peter H. Wilson “Absolutism in Central Europe” Routledge; 1 edition (November 1, 2002)

1990-1999 онд Цэргийн их сургууль

1999-2017 онд Батлан хамгаалахын их сургууль

2017 оноос Үндэсний Батлан хамгаалахын их сургууль”⁴⁹ гэж товчоолон нэрлэн ирснийг тус сургуулийн цахим танилцуулга хуудаснаас бэлээхэн харж болно.

Дээрх *цэргийн* сургууль буюу боловсролын байгууллагыг оноон орчуулахдаа *troops, soldier, forces* гэх ойролцоо утгатай үгнүүдийн аль нь ч тохирохгүй харин *military* гэх ганцхан үгээр оноон нэрлэх ёстой юм. Хэрэв оноон нэрлэсэн тухайн үгнээс өөрөөр ойролцоо үгээр орлуулах, нэрлэх тохиолдолд мэргэжлийн явцуу утга, үгсийн сангийн хүрээнд өөр утга санаа, ойлголт, нэр томъёо мэт буруу зөрүү ойлгогдох эрсдэл үүсэж болохыг үгүйсгэх аргагүй.

Монголын уран сайхны “Цэргийн хүү” (1966) киноны нэрийг монгол хэлнээс англи хэл уруу хөрвүүлэх шаардлага туршлагатай орчуулагчид тулгарлаа гэж бодоход мэдээж шууд махчилан орчуулан буулгаж болох эсэхийг хамгийн түрүүн нягтлах хэрэг гарна. Ингэхдээ орчуулах киногоо эхлээд үзэх, утга санааг нь ойлгон мэдсэний дараа л энэ нэрээр шууд орчуулж болох уу, эсвэл, өөр дүйцэл хайж олохоо шийдэж таарна. Монгол хэл, сэтгэхүйн онцлог киноны нэрэнд хэрхэн туссаныг бид харгалзах нь зүй ёсны хэрэг билээ. Энд хэн нэгэн цэргийн хүний хүү (аавын хүү, ээжийн охин гэдэг шиг) мэт хамаатуулан нэрлэсэн мэт боловч ерөнхий утгаар цэрэгт данстай хүн, албан хаагч гэсэн утгаар хэлжээ. Кинонд дайны хүнд бэрх цагт үед эх орноо батлан хамгаалан цэргийн албаа хааж буй Наваан нэртэй цэрэг эрийн тухай өгүүлдэг ажээ. Харин Зөвлөлт, Киргиз улсын нэрт зохиолч Чингиз Айтматовын (1928-2008) “Цэргийн хүү” (орос. “Солдатёнок”) өгүүллэгт гардаг гол баатар бол дайнд амиа алдсан цэргийн хүний өнчин хүү Авалбекын тухай өгүүлдэг. Зөвхөн энэ ижил нэртэй хоёр өөр бүтээл гэхэд л тус тусын ондоо утгаар хэрэглэгдсэнийг орчуулах хүн нь заавал судлан анзаарч мэдэх хэрэгтэй юм гэдгийг батлан харуулж байна.

“Эйженс Франс Пресс” мэдээллийн агентлагийн 2018 оны 09 сарын 07-ны өдрийн “US Army to Boost Strength in Germany by 1,500 Troops”⁵⁰ цахим мэдээнд *soldiers* гэхийн оронд *troops* хэмээх ойролцоо утгатай үгээр оноон нэрлэж бичсэн нь утгаа хамтын (нийтлэг) нэр гэсэн утгаар хэлсэн хэрэг билээ.

ҮБХИС-ийн бакалаврын төвшиний оюутнуудын үзэж судалдаг ерөнхий англи хэлний сурах бичиг болох “Campaign” (Цэргийн ажиллагаа) номын 3-р бүлгийн *To be a soldier* гарчигийг зөвхөн явцуу утгаар *цэрэг, цэргийн албан хаагч гэж хэн байх* тухай бус харин *цэргийн хүн байх* гэсэн өргөн, гүн утгаар ойлгох нь зүйтэй. Мөн сэдэв доороо *Great military leaders* буюу *Аугаа цэргийн жанжид* дэд сэдэвтэй. Үүнийг *цэрэг, цэргийн* гэсэн ганц л монгол үгэнд хоёр ондоо ойролцоо утгатай үг ашиглан хэрэглэсэн бас л нэгэн өөр тодорхой жишээ гэж үзэж болно.

Цэрэг гэх үгтэй холбоотой монгол хэлний аман болон утга зохиолын хэлэнд цөөн тооны хоршоо үг байдгийг эцэст нь товч боловч дурдах хэрэгтэй болов уу.

⁴⁹ <http://www.mndu.gov.mn/medeelel.aspx?mtype=101>

⁵⁰ <https://www.military.com/daily-news/2018/09/07/us-army-boost-strength-germany-1500-troops.html>

Тухайлбал, “Цэргийг мянган өдөр тэжээж, нэгэн цагт хэрэглэнэ” ч гэх юмуу, мөн “цэрэг цуух”⁵¹ гэх мэт. Тус тольд тайлбарлахдаа *цэрэг* гэдэг бол *эр цэрэг* буюу ганц тооны утгаар харин *цэрэг цуух* нь *цэрэг арми* буюу олон тоогоор ойлговол зохих ажээ.

Энэ бүхнээс гадна цэргийн мэргэжлийн нэр томъёоны өөр бас нэг гол онцлог бол маш их хэмжээний товчилсон баялаг үгсийн сан оршдогийг мөн анхааран үзүүштэй.

Цэрэг (цэргийн) хэмээх үгийг монгол хэлнээс англи хэл уруу орчуулахад утга зүй, өгүүлбэр зүй, үгсийн сангийн төвшинд дараах хүндрэлүүд гарах тул доорх хэдэн онцлогуудыг харгалзан авч үзэх учиртай.

Англи хэлний *troops(n), military (adj; n), soldier (n), forces (n)* гэсэн үгсийн аль нь ч тэр *цэрэг (цэргийн)* гэсэн утга агуулдаг;

Англи хэлнээс монгол хэл уруу орчуулан буулгахдаа тухайн үгийн өмнө *цэргийн* гэх тодотгосон үгсийг заавал дурдан хэрэглэх: тухайлбал *цэргийн хуаран (barracks), цэргийн дэлгүүр буюу тэдэнд зориулсан өргөн хэрэглээний үнийн хөнгөлөлттэй дэлгүүр (NATO Exchange), цэргийн цол (rank), цэргийн ажиллагаа (campaign)* ;

Ерөөсөө цэрэг гэсэн утга агуулдаг үгс: *явган цэрэг (infantry), усан цэрэг (navy), тэнгисийн цэрэг (marine)*;

Цэргийн мэргэжлийн англи хэлэнд хэвшин тогтсон зарим нэг нэр томъёог монгол хэл уруу утга зүйн төвшинд өөрчилж орчуулан буулгах тохиолдол цөөнгүй бий. Тухайлбал, *цэргийн анхан шатны сургалт (Basic Combat Training)*. Англи хэлний зарим үгс тэр бүр *цэрэг, (цэргийн)* гэх үгсийг огт дурдах албагүйг мөн анхааран үзвэл зохино. Тухайлбал, *combat* (дайн тулаан, байлдаан)

Цэргийн гэх толгой үгийн орчуулгын зарим жишээ:

Цэрэг, цэргүүд	troop(s)
Цэрэг (цэргийн хүн)	soldier, recruit, military
цэргийн алба хаагч (хугацаат)	serviceman, soldier, (conscript)
Цэрэг татлага (бүх нийтийн)	draft, conscription
Цэргийн	military, troop
~ баг	military contingent
~ баг илгээх	deployment (mission)
~ ажиглагч	military observer
~ ажиллагаа	campaign
~ алба	military service
~анхан шатны сургалт	basic combat training (BCT)
~ атташе	military attaché
~ байр	barracks
~ гавьяаны улаан тугийн одон	Order of Military Glory

⁵¹ Ж.Бат-Ирээдүй “Монгол үгийн утгыг үзүүлэх шинэ толь бичиг” УБ., 2015, 50-р талд

~ Дуу Бүжгийн Эрдмийн Чуулга	Military Song & Dance Academic Ensemble
~ дүйцүүлэх алба	alternative service
~ дэлгүүр	NATO Exchange/PX
~ зарлан дуудах	to be called up to the military
~ мэндлэх, хүндлэх ёс	military courtesy
~ цагдаа	military police (MP)
~ цол	rank
~ цол ахих	to be promoted
~ сургуулийн сурагч/сонсогч	cadet
~ сургуулилт	military exercise
~ тагнуул	military intelligence
~ төв эмнэлэг	central military hospital
~ музей	military museum
~ хөгжмийн сургууль	Military Music School
~ хүндэт медаль	Military Honor Medal
~ хоол, хүнс	military ration
~ хуаран	boot camp
~ хүчин	military forces
~ эргэлт	military coup
~ штаб	military staff
~ эргүүлэн татах	to withdraw
Цэрэгжүүлэх	militarism
Цэрэг зэвсгээр хөөцөлдөх	arms race
Цэрэггүй бүс	demilitarized zone
Цэрэг илгээх/хөдөлгөх	to send troops
Цэрэгт татагдах (мордох)	to enlist
Цэргээс халах	demobilize
Цэргийн алба хаах forces	to join the military/ to serve in armed forces

Цэрэг гэх нэр үгийн урдах тодотголын зарим жишээ:

Агаарын Цэрэг	air force
Ерөнхий Зориулалтын ~	joint military troop
Гэрээт ~	soldier on contract
Морьт ~	cavalry
Усан ~	sailor
Усан замын ~	marine
Хилийн ~	border troop
Хөлсний ~	mercenary
Шинэ ~	recruit
Шүхэр десантын ~	paratroop

Хуурай Замын ~	land forces
Төрлийн ~	service
Тэнгисийн ~	marine
Явган ~	infantry

Дээрх багахан хэмжээний толь бичигт энэхүү *цэрэг (цэргийн)* хэмээх ганц утга бүхий үг нь тухайн хам сэдэв, тухайн мэргэжлийн явцуу утга мэтээс шалтгаалан англи хэл уруу хэрхэн цөөн хэдэн өөр үгсээр тухайлбал, *military, forces, soldier, troop(s), conscript* гэх мэтээр оноон орчуулагдгах шаардлагатай юм гэдгийг батлан харууллаа гэж эцэст нь дүгнэж болно.

Summary

This paper deals how to translate precisely the only Mongolian word “цэрэг (цэргийн)” into English, which can be translated in the target language with some more words as “troop(s)”, “military” and “soldier” etc. However, it can be confusing for young translators as well as students as each of the words has its own profession related meaning in both languages depending on the context or speaking environment.

Ном зүй

- Бат-Ирээдүй. Ж “Монгол үгийн утгыг үзүүлэх шинэ толь бичиг” Уб.,2015.
“Цэргийн нэр томъёоны тайлбар толь” БХИС, Батлан Хамгаалахын Эрдэм Шинжилгээний Хүрээлэн, Уб.,2014.
Төмөртогоо. Д “Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь” Уб.,2018.
“Campaign-English for the military” Macmillan Education., 2004
“Oxford Mondar English-Mongolian Dictionary” First Edition, Уб., 2006
Peter H. Wilson “Absolutism in Central Europe” Routledge; 1 edition (November 1, 2002)
Zoya Proshina “Theory of Translation” (English and Russian)., Vladivostok Far Eastern University Press., 2008.
Интернет эх сурвалж:

www.webster.com

<http://www.mndu.gov.mn/>

<https://mongoltoli.mn/dictionary/>

<https://www.military.com/>